



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/384

Хэрлэн сум

Гадаа талбайд тусгай
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын дор дурдсан аж ахуйн нэгжүүд 3 дугаар багийн Баянмөнхийн цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд 2022 оны 7 дугаар сарын 10-ны 20:00-02:00 цагийг дуустал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

- | | |
|---------------|---------------------------|
| 1. Хэрлэн сум | “Их хаан сүлд” ХХК |
| 2. Хэрлэн сум | “Өнэд арвижих билэг” ХХК |
| 3. Хэрлэн сум | “Мөнх мандал хайрхан” ХХК |
| 4. Хэрлэн сум | “Хувь нэгтэн” ХХК |

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комиссын дарга (Л.Батсайхан), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Мэргэжлийн хяналтын газар (С.Сүнгээ), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

• 23101085